

Мөнхийн амьдрал ба мөнх шийтгэлийн хугацаа

Есүс Их Эзэн “хонин ба ямаан үндэстнүүд”-ийг дүгнэж хэлэхдээ: “Тэд мөнх шийтгэлд, харин зөвт нь мөнх аминд орох юм...” гэжээ (Матай 25:46)



Чуулганы алдартай "эцэг" Гиппо хотын Августин (МЭ 354-430) Есүсийн дээрх үгийг барьж хувь хүний орох “мөнхөд үргэлжлэх там”-ын тухай анх заадаг нэгэн байсан.

Гэтэл Матай 25:31-с гардаг шүүлтийг бид сайтар авч үзвэл Августины тайлбар буруу болохыг олж харна. Энэ бол эцсийн шүүлт биш, харин Есүсийг «Илчлэл» номд бичсэн аймшигт үеийн эцэст эргэн ирж Хаант улсаа байгуулахын эхэнд болох тодорхой зорилготой нэгэн шүүлт юм.



Энэ шүүлтээр нас барсан хувь хүмүүс биш, амьд яваа үндэстнүүд шүүгдэнэ. Шүүгдэх хэрэг бол тэдний итгэл биш, харин Есүсийн ах дүүс болох еврейчүүдэд хэрхэн хандаж байсан байдал нь. Есүсийг энэ дэлхийд эргэж ирэхийн өмнөхөн Иеремиагийн зөгнөлд “Иаковын зовлон” хэмээн нэрлэгдсэн үед еврейчүүд маш ихээр хавчигдах болно (Иеремиа 30:7, Матай 24:21). Есүсийн “нэрнээс болж” бүх үндэстэн ах дүүст нь үзэн ядсан ч (Матай 24:9), зарим нь тэр хэцүү зовлонт үед нь амь насаа дэнсэнд тавьж тэдэнд тусалсны төлөө шагнуулах нь зөв. Христийн хаант улсыг ах дүүс нь авч явна. Тийм учраас харьяат иргэд нь болох үндэстнүүдийн дундаас тусалсан нь шагнуулах учиртай, харин туслаагүйнүүд нь шийтгүүлэх нь зөв. Тиймээс энэ шүүлтээр үндэстнүүд Хаант улсад эзлэх нутгаа буюу байр сууриа хүлээн авна.¹

1 Матай 25. “31 **Хүний Хүү** алдраа дуурсган бүх тэнгэр элч нарынхаа хамт **ирж Өөрийн сүр жавхлантай сэнтийдээ залрах болно**. 32 Тэр **бүх үндэстнийг** өмнөө цуглуулж, **хоньчин хонио ямаанаас тусгаарладаг шиг** Тэр тэднийг нэг нэгнээс нь тусгаарлаад, 33 хонио Өөрийн баруун талд, ямааг зүүн талд байлгана. 34 Тэгээд **Хаан** Өөрийн баруун талд байгсдад хандан хэлэх нь “Миний Эцэгээр ерөөгдөгсөд өө, та нар нааш ир. Ертөнцийн сууриас та нарт бэлтгэсэн **хаанчлалыг өвлөн** авсугай. 35 **Учир нь** Намайг өлсөж байхад та нар Надад идэх юм өгсөн... 40... Та нар эдгээр **ах дүүсийн маань** нэгэнд нь, тэр байтугай хамгийн дордод нь тийнхүү **хандсан** бол Надад хийсэн хэрэг” гэж хэлнэ.” Жич: “Өвлөх” гэж орчуулсан үг энд “оноогдсон хувийг эдлэх” гэсэн утгатай. Энэ үгийг ялангуяа эзэмшил газар хүртэж авахад хэрэглэдэг байв. Жишээгээр Тооллого 34:13-г үзнэ үү.



Энэ талаар Иоел ч өмнө нь зөгнөсөн: **“Үзэгтүн, Иуда болон Иерусалимын хувь тавиланг сэргээх тэр үед [Хаант Улс нь эхлэхэд], тэдгээр өдрүүдэд Би бүх үндэстнийг цуглуулан... Тэгээд Би Өөрийн ард түмэн, Өөрийн өв болох Израилийн өмнөөс тэднийг тэнд шүүнэ”** (Иоел 3:1-2).

Их Эзэний Өөрийн ард түмэн мянган жилийн Хаант Улсад бусад үндэстэнг шударгаар захирч Бүтээгч Эзэний тухай заахад сонгогдсон билээ.



Тэгвэл тэдэнд

захирагдан, заалгах

үндэстнүүд байх ёстой нь мэдээж. Тийм байхад юуны өмнө тэдний хоорондох харилцааг засч залруулах бөгөөд уг Хаант Улсад эзлэх байр суурь, нутаг дэвсгэрийг нь тогтоох учиртай.

Эцсийн бус энэ шүүлтээр Есүс Эзэн “мөнх амь” ба “мөнх шийтгэл”-ийн тухай яриw.

Мөнхийн амьдрал хугацаатай

Нэгэнт “мөнх” гэдэг нь “төгсгөл нь харагдахгүй урт удаан хугацаа”-г хэлдэг учраас “мөнх амь” гэдэг нь айсуу эон үеийн сайн сайхан амьдралыг хэлж буйг бид өмнө нь олж харсан.



Мэдээж ирээдүйн эон үеийн туршийн гайхамшигт сайхан тэр амьдралыг итгэгч хувь хүмүүс хүртэх нь яриангүй. Үүнийг алдартай Иохан 3:16 зэрэг олон ишлэл амласан. Тухайлбал: “Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм.”

Гэтэл Есүсийн хэлснээр энэ “мөнх амь” Христэд итгэдэггүй ч, Түүний ард түмний хүмүүсийн хүнд хэцүү, хавчлага ихтэй үед сайхан сэтгэлээр хандаж тусалсан учраас “зөвт”-өд тооцсон үндэстнүүдэд ч заяагдах болно. Зөвт үндэстнүүд Христийн Хаант улсад амьдаараа орж сайн сайхныг нь хүртэж ивээгдэнэ гэсэн үг.²

Эонүүдэд тавьсан зорилго

Гэтэл Христэд итгэгч хүмүүс ганцхан дараагийн эон үед зогсохгүй, “мөнхөд бас дараа нь” жаргах болохыг ч бид мэдсэн. Энэ цувралын өмнөх хэдэн нийтлэлд танилцуулсан бүх ишлэлийг сайтар судалвал дараах ойлголт төрнө: Ертөнцийн Эзэний “эонүүдэд тавьсан зорилго” нь хэд хэдэн дараалсан урт хугацаат эон

2 Нэг эон үеэс дараагийн эон үед амьдаараа орсон хүмүүсийн жишээ бол Нуах ба түүний гэр бүлийнхэн. Тэдний төрсөн эон усан галвын гамшигаар төгссөн бөгөөд усан онгоцоосоо гарч ирэхэд нь шинэ эон үе эхэлжээ. Тэр эонд нь бид өнөөдөр ч амьдарсан хэвээр.



үеүдийн турш гүйцэтгэгдэнэ. Энэ талаар Нью Йорк хотын Union Theological Seminary дахь профессор байсан Марвин Винсент тайлбарлахдаа:


“Дэлхий ертөнцийн түүх хэд хэдэн дараалсан эон үеэр дамжин өрнөдөг болохыг Шинэ Гэрээнд харуулсан байдаг... Паул лав христитгэлт цаг үеэс өмнөх ба дараах эонүүдийн тухай бичдэг (Эфэс 1:21; 2:7; 3:9, 21; 1 Коринт 10:11; Еврей 9:26)...

“Эоний амьдрал” бол тасралтгүй үргэлжлэх мөнхийн амьдралыг биш, харин тодорхой нэгэн эоний турш үргэлжлэх амьдралыг хэлдэг.

“Эоний шийтгэл” бол ирээдүйн эонд явагддаг шийтгэлийг хэлнэ... Эоний амьдралын гол онцлог нь үргэлжлэх хугацаанд нь биш, сайн сайхан давуу мөн чанарт нь оршино...”³

Сатаны эрхшээлд буй одоогийн харанхуй, зовлон ихтэй, үхлээр дүүрэн, ёрын муу “ЭНЭ ЭОН ҮЕ” ашгүй төгсөх болно (2 Коринт 4:4; Галат 1:4). Есүс энэ дэлхийг захирахаар биеэрээ хүрч ирэхэд энэ эон дуусах бөгөөд гайхалтай сайхан “ИРЭХ ЭОН ҮЕ” эхлэх болно

3 «Шинэ Гэрээний үгийг судалсан нь» (3-р боть), 2 Тесалоник 1:9-д гардаг “мөнх сүйрэл” тухай тэмдэглэлээс нь





(Матай 12:32). Энэ бол Түүний байгуулах Хаант улсын үе бөгөөд энэ эон мянган жил үргэлжлэх болно. Есүст итгэдэг хүмүүс Аврагчийнхаа хамт байж яруу алдрыг нь хуваалцах ёстой учраас үхэгсдийн дундаас амилж тэрхүү эон үеийн турш зогсохгүйгээр дараагийн эон үеийн турш мөн адил Түүнтэй хамт жаргах болно. Шинэ тэнгэр, шинэ газар бүтээгдэх СҮҮЛЧИЙН ЭОН ҮЕ бүр ч гайхалтай сайхан байх болно. Тэр үед Ертөнцийн Эзэн Өөрөө хүмүүсийн дунд амьдрах учраас ямар ч зовлон, гашуудал, өвдөлт, үхэл дэлхийд байхгүй болно (Илчлэлт 21:1-4). Үүнээс дүгнэхэд мянган жилийн Хаант улсын эон үе хичнээн сайхан ч гэсэн зовлон ба үхлээс бүрэн чөлөөлөгдөөгүй байх болно.

Ямартай ч, Есүст итгээгүй үхэгсэд Хаант улсын эон үед Иохан 3:16-н хэлснээр “мөхсөн” хэвээр байх болно. Юу гэвэл, тэд “үүрдийн нойр”-ноосоо сэрэх болоогүй, “мөнхийн гэр”-ээсээ гарах болоогүй, үхсэн хэвээр байх болно. Тэд айсуу сайн сайхан эоний ивээлүүдээс хасагдана.

Ивээлээс тодорхой хэмжээгээр хоцрох нь мөн хараагдсан “ямаан үндэстнүүд”-ийн ч шийтгэл билээ.



Мөнхийн шийтгэл ч хугацаатай

“Ямаан” үндэстнүүдэд заналхийлсэн “мөнх шийтгэл”-ийг ойлгох ойлголтыг нээх нэгэн том түлхүүр бол “шийтгэл” гэж орчуулсан грек үг юм. Тус үгийг (κόλασις, “коласис”) анх ёс суртахуунд биш, хөдөө аж ахуйд хэрэглэдэг



байсан бөгөөд “модыг илүү их үр өгөөжтэй болгохын тулд тайрах” гэсэн утгатай байлаа. Дараа нь “засч залруулах зорилгоор оноосон шийтгэл” гэсэн утгаар хэрэглэгддэг болсон.

Аристотлийн дагуу, “шийтгэл, өшөө, яллагаа” гэж орчуулах грек үг (τιμωρία) бол өшөө авагч нэгний үр ашгийг чиглэсэн байдаг. Энэ үг «Шинэ гэрээ»-нд ганц удаа буюу Еврей 10:29-т гарна.⁴ Харин “коласис” (κόλασις) бол шийтгэгдэж буй хүний сайн сайхныг зорьдог. (Энэ хоёр үгийг АБ ялгадаггүй, аль алиныг “шийтгэл” гэж орчуулсан.)

4 “Бурханы Хүүг уландаа гишгэж, өөрийг нь ариусгасан гэрээний цусыг бузар хэмээн үзээд нигүүлслийн Сүнсийг доромжилсон хүн хэр зэрэг илүү хүнд шийтгэл эдэлбэл зохино гэж та нар бодож байна? Учир нь “Өшөө авалт нь Минийх. Хариуг нь Би өгнө” гээд, дахиж “Эзэн Өөрийн хүмүүсийг шүүнэ” гэж айлдсан Түүнийг бид мэднэ.”



Тухайн үед “хэзээ ч дуусашгүй шийтгэл” гэсэн утгатай өөр үг байгаагүй биш, байсан.

Есүсийн үеийнхэн болох Фарисайчууд муу хүмүүсийг дуусашгүй тарчилгаагаар шийтгүүлэх болно гэж үздэг байжээ.

Энэ онол сургаалаа тодорхой үгээр нэрлэдэг байсныг бид түүхч Иосеф Флавийгээс мэднэ. Фарисайчуудын хэрэглэдэг

нэр томъёо нь:

--“дуусашгүй тарчилгаа” (“timorion adialeipton”),

--“үхэшгүй үхэл” (“thanaton athanaton”),

--“эцэс төгсгөлгүй үхэл” (“thanaton ateleuteton”) зэрэг хэллэг билээ.

Энэ сургаалаа тэд «Хуучин Гэрээ»-нээс биш, харин «Енох» зэрэг иудей номноос, мөн Грек, Египет ба Вавилоны шашнаас олж авсан.



Хэрэв Есүс Фарисайчуудын итгэдэг дуусашгүй шийтгэлийг ярих санаатай байсан бол тэдний нэр томъёог адилхан хэрэглэх байхсан. Гэтэл Их Эзэн маань эрс өөр үг сонгон, “эон үеийн турш үргэлжлэх сахилгажуулах шийтгэл”-ын тухай ярьсан. Түүний үгийн сонголтоос харахад, Их Эзэний оноогддог шийтгэл нь шийтгэгдэж буй нэгний сайн сайхныг зорьдог. Түүний шийтгэл нь



“эон үеийн гал”-аар явагдсан ч сүйтгэхийн тулд биш, харин засч сэргээх зорилготой. Тэгвэл Матай 25:46 нь дуусажгүй тарчилгааны тухай биш, харин зөвт бус үндэстнүүд “эон үеийн турш үргэлжлэх, засаж залруулах шийтгэл авах” тухай юм. Энэ шийтгэл яг хэрхэн явагдахыг баттай хэлж мэдэхгүй.⁵

Одоогийн байдлаар гол ойлгох зүйл бол энэ: Бүтээгч Эзэний оногдох шийтгэлд дуусашгүй чанар алга.

Содом хотын хувь заяа ч үүнийг харуулна. Содом хот гэм нүглээрээ алдартай бөгөөд Абрахамын үед галаар устгагдсан билээ. Тэдэнд оногдсон галын шийтгэл мөн адил “мөнхийн” чанартай юм (*“Содом, Гоморра болоод эргэн тойрных нь хотууд ... завхайралд автагдан, өөр гаж махан биеийн араас явсан тул мөнхийн галын шийтгэлд өртөхийн жишээ болдог юм.”* Иуда 7).

- 5 Энэ талаарх бодлоо хуваалцахад, нэг бол “ямаан үндэстнүүд” үндэстэн байхаа болино. Гэтэл ямаануудаа хоньдоосоо тусгаарлаад устгадаг хоньчин байдаггүй биз ээ. Тиймээс дараах дүгнэлтэд хүрсэн: Тэд амьдаараа шинэ эон үед орж мянган жилийн хаант улсад хамрагдана, гэхдээ Их Хаан Есүсийн залрах ивээлтэй хот Иерусалимаас “зайлж” (Матай 25:41) хамгийн алслагдсан газарт нутаглах хувь оноогдоно. Иерусалимын ивээгдсэнтэй харьцуулахад тэр алслагдсан газар нутаг хараагдсанд тооцож болно. Ямартай ч, тэр мянган жилийн эцэст Сатаныг суллагдангуут “дэлхийн дөрвөн өнцөгт буй үндэстнүүд” түүнд мэхлүүлж “хайрлагдсан хот” Иерусалимын эсрэг байлдахаар цугларна. Гэтэл “тэнгэрээс гал бууж тэднийг залгих” болно (Илчлэлт 20:8-10). Есүс тэр галыг хэлсэн байж магад.



Гэвч өнөөдөр Содом байсан газар очвол “мөнхийн” гал тэнд харагдахгүй, харин ч Мөхсөн Тэнгис оронд нь байдаг болсон. “Мөнхийн гал” нь унтарсан ч тус шийтгэлийн үр дүн өнөөгийн эон үеийн турш үргэлжилсний хувьд “мөнхийн” буюу өнөө эон үеийн турш үргэлжлэх чанартай болох нь ойлгогдож байна.

Гэсэн хэдий ч Ертөнцийн Эзэн Содом хотынхныг сэргээж, урьдын газарт нь буцаана гэсэн гайхшрал төрүүлэм амлалт бий. Тухайлбал: “Би Содом болон түүний охидыг... олзноос сэргээн, мөн тэдний хамт чамайг [=Иудаг] өөрийг чинь олзноос гаргана... Чиний эгч дүүс болох Содом охидтойгоо хамт... өөрсдийн урьдын газарт буцаж, бас чи охидтойгоо хамт өөрийн урьдын газартаа буцаж ирнэ.” (Езекиел 16:53-55).



Үүнээс харахад Содомын “мөнхийн” шийтгэл хэм хэмжээтэй (эоний турш л үргэлжлэх) бөгөөд нэг л өдөр өнгөрсөн байх болно. Их Эзэний “мөнхөд... тэгээд дараа нь” гэсэн зарчим Содом хотын хувьд ч үйлчилнэ.

Энэ бүхнийг бодохоор Матай 25:46 нь үнэхээр эрс өөр сонсогдож байна.⁶

Христэд итгээгүй хувь хүмүүсийн хувь заяа

Христэд итгэлгүй нас барсан хувь хүмүүсийн “мөхөл” (Иохан 3:16) мөн адил хугацаатай.

Есүсийг эргэж ирэх үед тэд дахин амилахгүй.

Мянган жилийн эон үеийн жаргалыг нь тэд хуваалцахгүй гэсэн үг.

Харин тэрхүү эон үе өнгөрсний дараа итгэгч бус үхэгсэд бүгд дахин амилж, Христийн цалин цагаан сэнтийн өмнө зогсож, хийсэн сайн муу үйлсийнхээ дагуу шүүгдэх болно (Илчлэл 20).

6 “Дуусашгүй мөнх” гэж ойлгогддог үгийг (“eternal”) хэрэглээгүй Библийн англи орчуулга олон бий. Матай 25:46-т гардаг “мөнх шийтгэл”-ийг өөрөөр орчуулдаг дөрвөн орчуулга танилцуулахад:
-*Young’s Literal Translation*: “punishment age-during” (эрин үеийн хугацаагаар үргэлжлэх шийтгэл)
-*Rotherham Translation*: “age-abiding correction” (эрин үеийн турш орших засал)
-*Weymouth Translation*: “punishment of the ages”(эрин үеүдийн шийтгэл)
-*Concordant Literal Translation*: “chastening eonian” (эоний туршийн сахилгажуулал)
Ингэж орчуулахад утга нь эрс өөр болдог. Дараалсан эрин үеүдэд эхлэл ч бий, төгсгөл ч бий.

Цагаан бол зөв шударгыг илэрхийлэх өнгө (Илчлэл 19:8,11). Тэд Лазар шиг дахин амилсан ч “амьд болгогдох” буюу үхэшгүй амьтай болох цаг нь болоогүй байна.

Энэ шүүлт хүн төрөлхтөний түүхэнд гарсан болохгүй, буруу хэрэг бүрийг засч залруулах зорилготой. Үүний тулд хүн бүрийн буруу ойлголтууд засагдах ёстой. Энэ шүүлтээр дамжин хүмүүс гэмийг нь аль



хэдийнэ үүрсэн Аврагч Эзэнтэйгээ танилцахад Ертөнцийн Эзэн ба хувь хүний хоорондох харилцаа зогсохгүй, хүн хүний хоорондох бүх харилцаа засагдахад хүрнэ.

Нэрс нь амийн номд бичигдсэн хүмүүс амьдаараа дараагийн эон үеийн шинэ газар дэлхийд очиж амьдрах болно. Гэвч нэр нь амийн номд бичигдээгүй их муу үйлстэй хүмүүс дахин үхэх ял авч “хоёрдахь үхэл болох галт нуур”-анд орох болно. Тэр үед дуусашгүй галаар шатах тамд орно гэж үү? Үгүй!

Фарисайчуудын дээр дурдсан аймшгийн нэр томъёо «Шинэ Гэрээ»-ний хаанаас ч олдохгүй. Хэн ч тэдний төсөөлөөд байсан “дуусашгүй



тарчилгаа”-гаар зовохгүй. Тийм юм байдаггүй. Харин ч “Ертөнцийн Эзэний үгийг хүчингүй болгодог” Фарисайчуудын уламжилсан сургаалаас Есүс дагалдагч нараа ба мөн биднийг болгоомжлуулсан (Марк 7:13; Матай 6:12). Харамсалтай нь, Фарисайчуудын “үхэшгүй үхэл”-ийн тухай сургаал үнэхээр хөрөнгө шиг тархаж, Христэд итгэгчдийн итгэлд шингэж орсон. Есүсийн үгийг зөв ойлгож авах цаг хэдийнэ болсон байна!

Галт нуурын ял авсан хүмүүс цаазлагддаг. “Хоёрдахь үхэл”-д орсон хүн бусад үхсэн хүний адил юу ч мэдэхгүй, юу ч мэдрэхгүй. Үхэл бол сүүлчийн дайсан (1 Коринт 15:26). Үхэл хүчингүй болох тэр мөчид энэхүү шийтгэл ч гэсэн төгсөх болно. Бүтээгч Эзэний төлөвлөгөөнд “мөнхийн дараа” төлөвлөсөн юм байгаа учраас тэр. Бидний баттай мэддэг зүйл бол энэ: Их Эзэн маань шударга ёс эвдэгдэхээр хилэгнэдэг. Тэрээр “хувиршгүй үнэнч хайраа харуулахдаа ... сэтгэл тааламжтай болдог учраас уур хилэнгээ үеийн үед [үргэлж] хадгалж байлгадаггүй билээ”. Тэрээр хүн төрөлхтөнд дахин “нинжин сэтгэлээ харуулан, хийсэн бүх гэмийг маань хөл дороо дэвслээд хөлгүй далайн гүнд шидэх мэт хүршгүй хол газарт зайлуулан хаях болно” (Мика 7:18-19, ББ).



Есүс загалмай дээр нэгэнт “ертөнцийн нүглийг үүрсэн [грек: авч хаясан]” учраас хүн болгоныг энэрч “амьд болгогдох” нь

Ертөнцийн ариун Эзэний хувьд туйлын зөв шударга билээ (Иохан 1:29).


Христийн ажлын үр дүнд л Ертөнцийн Эзэн хүн бүрийн гэмийг “дорно, өрнийн хоорондох зай мэт холын холд зайлуулсан билээ... Учир нь, хүмүүс бидний хэмжээ хязгаарыг Тэр үргэлж тооцдог билээ. Бид зөвхөн газар шорооноос үүсэлтэй гэдгийг Тэр үргэлж санадаг болой” (Дуулал 103:9-14, ББ).

Христийн загалмай дээр бүтээсэн “зөвт үйлээс болж бүх хүмүүс амийн зөвтгөлд” хэзээ нэгэн цагт хүрэх болно (Ром 5:18). Тэгэхээр “Адамын дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьд болгогдох болно. Харин тус бүр өөрийн дараалал дотор” (1 Коринт 15:22). Эон үеүдийн төлөвлөгөө гүйцсэн цагт Ертөнцийн Эзэн “бүгдийн дотор бүх юм нь” болно (1 Коринт 15:28).

Ингээд “газар дэлхийн бүх овог ураг чамаар дамжин ерөөгдөнө” гэж Абрахамд амласан Их Эзэний амлалт бүрэн биелэх болно (Эхлэл 12:3, СМО). Үр дүнд нь “бүх махбод Түүний ариун нэрийг эон үеийн турш бас дараа нь магтах” болно (Дуулал 145:21).

Гайхалтай нь, “эон” гэдэг грек үгийг зөв утгаар нь ойлгож, улмаар Ертөнцийн Эзэний “мөнхөд... бас дараа”-г багтаасан төлөвлөгөөг ойлгож авсан юм бол “хэзээ ч дуусахгүй үхэл” эсвэл “зовлонт там”-ын тухай ойлголт Библид байхгүй болохыг олж харах болно.

Оронд нь бид **зонүүдийг багтаасан Их Эзэний төлөвлөгөөг** улам сайн ойлгоход хүрнэ.





Түүний хамгаас мэргэн, төгс тэр төлөвлөгөөнд шийтгэл зайлшгүй байсан ч гэсэн, “мөнхөд үргэлжлэх үхэл” багтахгүй нь лавтай.

Энэ төлөвлөгөө нь Түүний хэзээ ч хувиршгүй, туйлын хүч чадалтай Хайранд тохирно.

Энэ төлөвлөгөө дайснаа хүртэл хайрладаг Нэгэнд зохино. Өөрийнхөө урласан зүрх сэтгэл бүрийг Тэрээр заавал энэрч Өөртэйгээ эвлэрүүлэх болно (Дуулал 33:15; Колоссай 1:20). Өөрийнхөө өгсөн бүх амлалтыг Тэрээр зайлшгүй биелүүлэх болно. Төгс ариун Тэрээр ариун дархан Үгээ хэзээ ч эвдэхгүй.

Ер бусын Эцэг маань Өөрийг нь “Сүнсээр ба Үнэнээр” хүндлэх үнэн итгэгчийг эрэлхийлдэг (Иохан 4:24). Бид Түүний Үнэнийг мэдэж авсан үедээ л Түүнийг зөвөөр таньж, үнэн сэтгэлээсээ хүндлэх боломжтой. Хичнээн олон хүмүүс мөнхийн тамд орсноос айдаг айдсын улмаас Түүнийг хүчээр “хүндэлдэг” болохыг бүү мэд. Өнөөдрөөс эхлэн та Библи уншихдаа Ертөнцийн Эзэний сайн зан чанар, Түүний төгс хүсэл зорилго, Түүний найдвартай төлөвлөгөөнд үндэслэсэн “мөнхөд... бас дараа нь” гэсэн зарчмыг эрэлхийлэн байж уншаарай. Их Эзэн таныг Өөрийнх нь Хайрын өндөр, гүн, урт, өргөнийг хэмжиж, хязгаарыг нь олоход таныг уриалж байна (Эфэс 3:14-19).

Түүний Хайр ХЭЗЭЭ Ч ДУУСДАГГҮЙг та олж мэдэх болно (1 Коринт 13:8).

“Мөнхийн [эоний] хайр” гэсэн хэллэг Бичвэрүүдэд байхгүй нь учиртай. Их Эзэний Хайр дуусна гэж байхгүй, тасарна гэж байхгүй, харин мөнхөд ба түүнээс ч хойш үргэлж үргэлжлэх нь лавтай учраас тэр. □



Дараагийн нийтлэлдээ “Мөнхийн Эзэн” ба Түүний “мөнхөд тогтох үг”-ийн хугацааг авч үзэх болно.

Ашигласан эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон.

---Библи (2015). Улаанбаатар: Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.

---Hanson, J.W. (1899). Universalism: The prevailing doctrine of the Christian Church during its first five hundred years (and showing the influence of Greek mythology and pagan philosophy on Christian doctrine). Boston and Chicago: Universalist publishing house. Retrieved July 20, 2019 from <https://tentmaker.org/books/Prevailing.html#271>

---Jones, S.E. (2019). The Meaning of Eternal and Everlasting. Retrieved from <https://www.gods-kingdom-ministries.net/teachings/articles-and-poetry/the-meaning-of-eternal-and-everlasting/>

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон.

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org

---Vincent, M.R. (1887). Word studies in the New Testament, Volume 3 & 4. Retrieved from <https://www.hopefaithprayer.com/books/Word-Studies-in-the-New-Testament-Vol-3&4-Marvin-R-Vincent.pdf>